

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГААС ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар” гэх)-аас хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

1.2.1.төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, нэг цонхоор хүртээмжтэй хүргэх;

1.2.2.үйлчилгээ үзүүлэх явцад олж мэдсэн хүний хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх;

1.2.3.төрийн үйлчилгээний стандартыг ханган ажиллах;

1.2.4.хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх ажиллагаа нэгдсэн тогтолцоо, удирдлагатай байх.

1.3.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас үзүүлэх үйлчилгээг дараах байдлаар ангилна:

1.3.1.лавлагаа, тодорхойлолт;

1.3.2.“нэг шатлалт үйлчилгээ” гэж үйлчилгээний хүсэлтийг хандсан цэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариу өгөх боломжтой үйлчилгээг;

1.3.3.“олон шатлалт үйлчилгээ” гэж нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх үйлчилгээг.

Хоёр.Хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх

2.1.Хүн, хуулийн этгээдийн үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч бүртгэхдээ иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах цаасан, цахим бичиг баримт, цахим гарын үсэг, эсхүл Засгийн газраас тогтоосон арга, хэрэгсэл бүхий танилт, нэвтрэлтийн системийг ашиглан таньж баталгаажуулсан байна.

2.2.Үйлчилгээ үзүүлэх ажилтан энэ журмын 1.3-т заасан үйлчилгээг хүлээн авсан талаар бүртгэл хөтөлнө.

2.3.Үйлчилгээ үзүүлэх ажилтан энэ журмын 1.3.1, 1.3.2-т заасан үйлчилгээг шийдвэрлэсэн тухай мэдээллийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр өгнө.

2.4.Үйлчилгээ үзүүлэх ажилтан энэ журмын 1.3.3-т заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах баримт бичгийн бүрдлийг нягталж, шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.

2.5.Энэ журмын 1.3.3-т заасан үйлчилгээг шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд шилжүүлсэн, шийдвэрлэсэн, буцаасан, татгалзсан талаарх мэдээллийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр үйлчилгээ авах хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдэд тухай бүр өгнө.

2.6.Энэ журмын 1.3.3-т заасан үйлчилгээг шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд шилжүүлсэн тохиолдолд хууль, журамд заасан хугацаанд шийдвэрлүүлэх талаар эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

2.7.Хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем, төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машин болон хувийн хэвшлийн киоск машин, мэдээлэл хариуцагчийн системээр дамжуулан хүлээн авч болно.

2.8.Хэрэв тухайн хэрэглэгчийн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй, үйлчилгээний жагсаалтад багтаагүй бол тус үйлчилгээтэй холбоотой зөвлөмж өгч чиглүүлж болно.

Гурав.Бусад

3.1.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас үзүүлэх үйлчилгээний жагсаалтад өөрчлөлт оруулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр саналаа цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.2.Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг сайжруулах судалгааг хийж, дахин загварчлах, боловсронгуй болгох саналаа эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3.Төрийн үйлчилгээ үзүүлэх ажилтан үйл ажиллагаандаа холбогдох стандарт, журам, холбогдох бусад шийдвэр, үйлчилгээний чанарыг мөрдөж ажиллаж байгаа эсэхэд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар

хяналт тавьж, тайлангаа цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэгээс доошгүй удаа хийж, судалгааны тайланг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.5.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх ажилтныг сургах, мэргэшүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, холбогдох сургалтыг тогтмол зохион байгуулна.

3.6.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хүн, хуулийн этгээдийн төлбөр төлөх, төлбөрийг буцаах боломжийг бүрдүүлсэн байна.

3.7.Үйлчилгээ авах хүсэлтийг эрх бүхий байгууллагаас шийдвэрлэсэн тухай баримт бичгийг хүн, хуулийн этгээдэд хүргэх боломжийг бүрдүүлнэ.

3.8.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

----oOo----